



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 1/22

Хатан суудал

**Г САР ШИНИЙН БАЯРЫГ УГТАН БҮХ
НИЙТИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ**

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 66.1, байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6, хог хаягдлын тухай хуулийн 9.4.1, 9.4.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн захирамжлах нь:

1. Бүх нийтийн цэвэрлэгээг 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр айл өрхүүдийг 10-13 цагийн хооронд, аж ахуй нэгж, албан байгууллага, дэлгүүр, шатахуун түгээх станцуудыг 14-16 цагийн хооронд тус тус хамруулан зохион байгуулсугай.

2. Цэвэрлэгээний явц болон аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Гэрэлмаа, байгаль хамгаалагч Ц.Золбаяр, Хатан суудал 5-р багийн засаг Б.Амаржаргал нарт, нийтийн цэвэрлэгээний өдөр сумын төвд байгаа айл өрхүүдээ цэвэрлэгээнд идэвхтэй хамруулахыг Багийн засаг дарга Д.Батаа, Ц.Намхайхорол, А.Элдэв-Очир, С.Баттулга нарт, цэвэрлэсэн хог хаягдлыг тухай бүрд ачихыг хог тээврийн жолооч С.Ням-адъяа, ачигч Д.Нямдорж нарт үүрэг болгосугай.

3. Тогтоосон хугацаанд дэлгүүр, шатахуун түгээх станцуудын үйл ажиллагааг түр зогсоож ажиллахыг хэсгийн төлөөлөгч Д.Бадарчин, Цагдаа Л.Пүрэвсүрэн нарт даалгасугай.

4. Лагерь хорооллуудыг хариуцаж цэвэрлэгээнд идэвхтэй хамруулах албан хаагчдын хуваарийг хавсралтаар баталсугай.

642501015

5.Цэвэрлэгээнд оролцсон болон оролцоогүй айл өрх, аж ахуй нэгжүүдийг бүртгэж, бүртгэлийг 2025 оны 02 дугаар сарын 21-ны өдөр Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Гэрэлмаад танилцуулахыг хороолол хариуцсан албан хаагчдад даалгасугай.

6.Нийтийн цэвэрлэгээнд гараагүй айл өрх, аж ахуй нэгж албан байгууллагуудад хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Гэрэлмаад үүрэг болгосугай.

7. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (С.Эрдэнэбаярт) үүрэг болгосугай.



Сумын Засаг даргын 2025 оны 02
дугаар сарын 29 ны өдрийн 1/22
дугаар захирамжийн хавсралт

ХОРООЛЛУУДЫГ ЦЭВЭРЛЭГЭЭНД ГАРГАХ АЛБАН ХААГЧДЫН
ХУВААРЬ

№	Хорооллын нэр	Албан хаагчдын нэр
1	Нарлаг, цэргийн анги	С.Эрдэнэбаяр, Ц.Золбаяр Д.Батаа
2	Жаргалант	С.Баттулга, Б.Гэрэлмаа
3	Өлзийт	А.Элдэв-Очир, Ц.Цэндцэвээн
4	Уран хайрхан	Ц.Намхайхорол, П.Норовсамбуу
5	Харзтай	А.Цэнд-Очир, Д.Цэндбаяр
6	/Төвийн бүс/ Дэлгүүрүүд, Шатахуун түгээх станц, 3 давхар, хуучин эмнэлэг	Б.Амаржаргал, А.Гантулга, Б.Галдан

Жич: 16 цагаас албан байгууллага, дэлгүүр, айл өрхүүд хариуцсан
газруудаа цэвэрлэж дуусаад сурын талбайгаас самбар хүртэл цэвэрлэх